

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашдондог	Дугаар	L273
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэ сум
Төрсөн газар	Эрдэнэ сум	Төрсөн он	1927
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жанчивлин хийд	Сүм хийдийн дугаар	ТӨЭР 049
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны11-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Төв аймгийн Эрдэнэ сумын Жанчивлин хийд

Мөнхбат:Тэгэхээр Дашдондог багш та энэ Эрдэнэ сумын нутагт байх тухайн үеийн Түшээт хан аймгийн Дархан Чой вангийн хурал номын томоохон төв байсан Жанчивлин хийдийн тухай одоо түүхээс нь бидэнтэй хуучилна уу ?

Дашдондог: Тэгэхээр дээр үед 1830-аад онд тэр хийдийг байгуулсан юм шүү дээ. Тэгэхдээ тэр Мөнгөнморьтод Хөгшин хүрээ гэж байсан юм, зүүн хүрээ гэж тэр хүрээнээс 200-аад лам авчирсан гэдэг юм байна лээ шүү.Тэгээд энд тэр 9 сүмтэй дуганг байгуулсан. Тэгэхдээ тэр Даржаагийн хүрээ гэж байсан.Тэгээд тэр Даржаагийн хүрээг Дөрөвдүгээр богд Жанчивлин болгосон юм гэдэг. Тэрнээс Жанчив гэлэн гэсэн үг биш шүү дээ, зарим хүмүүс тэгээд байдаг. Жанчивлин гэж, лин гэдэг чинь хийд гэсэн үг юм байна шүү дээ. Тийм , Гандантэгчилэн, Шадавлин гэж.Тэгээд Дөрөвдүгээр Богд Жанчивлин гэдэг өргөмжлөл өгч байсан юм билээ, 200-аад ламтай байсан юм уу. Дараа нь бол Богдхан уулын аймгийн Богдхан уулын хошуу мөн төвлөрч байсан.Тэр ч байтугай тэнд анхны тэнхим байсан, анхны сургууль төвлөрч байсан юм. Тэнд анхны багш,шавь багш нь болвол Жигмэд тайж гэж хүн байсан юм. Анхны шавь нь бол Санжийн Батаа. Батаа генерал анхны шавь нь байсан. Тэр ч байтугай тэнд нусхай Дэндэв гээд байж байна, Ринчен гээд байж байна, Сам гээд байж байна. Тэр анхны шавь нар байсан гэж надад Санжийн Батаа гуай ярьж байсан юм аа. Би Жанчивлинд анхны музей байгуулж байхдаа энэ талаар судалгаа хийж байхад Батаа гуай надад 20 хүүхдийн нэрийг өөрөө цээжээр шууд бичээд өгч байсан, овог нэрийг нь.Үгүй тэхээрээ нэлээн толгойтой хүн байжээ гэж боддог юм аа. Тэгээд дараа нь тэр Богдхан уулын хошуу шүү дээ, хүрээ байсан газар чинь. Тэгээд Богдхан уулын хошуун дээр тэр 1924 онд тэр тэнхим байгуулсан байхгүй юу.

Мөнхбат: Даржаагийн хүрээ гэж яагаад нэрлэсэн юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дашдондог: Даржаагийн хүрээ гэж л нэрлэж байсан юм гэнэ лээ. Би тэрнийг сайн мэдэхгүй юм аа. Даржаагийн хүрээ л гэдэг юм. Дараа нь Жанчивлин болсон, 200 ламтай, 9 сүмтэй байсан. Ийм л юм даа.

Мөнхбат: Ямар ямар хурал хурдаг байсан юм бол, цам майдар эргэх, цам харайх, майдар эргэх зэрэг ямар ямар шашны зан үйл явдаг байсан юм бол? Жас хөрөнгийн хувьд ямар байсан юм бол?

Дашдондог: За тэрийг би ёстой үнэндээ сайн мэдэхгүй ээ.

Мөнхбат: Та тэр хүрээний гол цогчин дуганы макетыг хийсэн гэсэн. Тэрний их загвар зургийг хаанаас авч хийсэн байдаг юм, ямархуу сүм байсан юм бол оо?

Дашдондог: Би гүнжин сүмийн макетыг Төв аймгийн музей судлаач Эрдэнэбат 80 жилийн ойгоор тэр гүнжин сүмийн макетыг хийж өгсөн байхгүй юу. Тэгээд тэрнээс үндэслээд би өөрөө санаанаасаа ийм юм байх болов уу гээд хйичихсэн юм.

Мөнхбат: Одоо 9 дуганы үл мөр ямархуу хэмжээнд байна?

Дашдондог: Одоо тэндхийн тэр скалад байгаа хашаан дотор туурь нь байсан юм аа. Одоо ч байгаа л даа.

Мөнхбат: За маргааш бид нар очоод тэнд, хэмжилт аваад судалгаагаа хийнэ. За одоогоор хоёулаа ярилцлагаа завсарлалчихая.